

# ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026 БАГА СУНГАА СОРИЛ

## Хувилбар А

### I. НИЙГЭМ, НИЙГМИЙН ХАРИЛЦАА

1. Хүмүүс хэрэгцээгээ хангах, зөрчил маргаан, эмх замбараагүй байдалд хүргэхгүйн тулд үүргээ хуваарилан, зохион байгуулалтад орж, хянаж зохицуулах замаар амьдарч буй хамтын амьдралын хэлбэр бол..... юм. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. Нийгмийн байр суурь    B. Нийгмийн бүтэц    C. Нийгэм  
D. Нийгмийн үүрэг    E. Нийгмийн институт

2. Хүүхдүүд хамтран тоглох явцдаа дүрмээ хэлэлцэн тогтож, зохион байгуулалтад орж, бие даасан шийдвэр гаргах, гэр бүлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоход суралцдаг. Энэ нь нийгэмшилтийн аль агентад хамаарах вэ? /1 оноо/

- A. Сургууль    B. Үе тэнгийнхэн    C. Гэр бүл  
D. Хэвлэл мэдээлэл    E. Ажлын байр

3. Доорх ойлголтуудыг тодорхойлолттой нь зөв харгалзуулна уу. /3 оноо/

a	Нийгмийн гажуудал (девиаци)	1	Нийгмийн хэм хэмжээ, хүлээлтэд нийцэх төлөвийг хэлнэ.
b	Аялдах үйлдэл (конформист)	2	Гажуудлыг арилгах үүднээс нийгмийн гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх зэрэг хэлбэрээр авч буй арга хэмжээнүүдийн цогц юм.
c	Нийгмийн хяналт	3	Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлтэй үл нийцэх төлөвийг хэлнэ.

- A. a1, b2, c3    B. a1, b3, c2    C. a3, b2, c1  
D. a3, b1, c2    E. a2, b3, c1

4. Тоон судалгааны аргын онцлогийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Задгай мэдээллээс ерөнхий сэдэв, нотолгоо гаргахыг зорино  
B. Мэдээлэл нь ажиглагдсан зан үйл, үг яриа байна  
C. Мэдээллийн утгыг ойлгох, дүрслэн харуулахаар зорино  
D. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг бичих албагүй  
E. Математик статистикийн аргуудаар шинжилгээ хийнэ

5. XX зуунд Монгол улсын хүн ам 647.5 мянгаас 2373.5 мянга болж бараг 4 дахин өссөн нь нийгмийн ямар үзэгдэлтэй холбоотой вэ? /1 оноо/

- A. Нийгмийн өөрчлөлт    B. Нийгмийн давхраажилт  
C. Нийгмийн гажуудал    D. Нийгмийн судалгаа    E. Нийгмийн бүтэц

6. Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдах нь нийгмийн ямар үзэгдэл вэ? /1 оноо/

- A. Нийгмийн нийтлэг    B. Нийгмийн давхраажилт  
C. Нийгмийн ялгарал    D. Тэгш бус байдал    E. Нийгмийн давхраа

7. "Тун бага хувийг эзэлдэг ч нийгмийн баялгийн дийлэнх хэсгийг эзэмшдэг. Нийгмийн байр суурь нь үе залгамжилдаг" энэ шинжүүд нийгмийн ямар ангид хамаарах вэ? /1 оноо/

- A. Дээдийн доод    B. Дээдийн дээд    C. Дундын дээд  
D. Дундын дунд    E. Ажилчин анги

8. Нийгмийн давхраажилтыг судлах зөрчилдөөний онолын гол хандлагыг тэмдэглэнэ үү. /1 оноо/


- A. Бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг.  
B. Нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарал бол нийгмийн давхраажилтын суурь шалтгаан мөн  
C. Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүрэх үндсэн шалтгаан мөн  
D. Эрх мэдэл бүхий хэсэг өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу нөхцөлд байх бол бусад нь тэрхүү ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр нөхцөлд байна  
E. Нийгмийн давхраажилт бол уламжлал, тогтсон байдлаас шалтгаалан өөрөө жам ёсоор оршин тогтнодог үзэгдэл мөн

9. Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс Янки хотын нийгмийн давхраажилтыг судалсан судлаач Л. Уорнерын жишээ загвар аль нь вэ? /2 оноо/

- A. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзэнээс дээд ангид оруулж судална.  
B. Ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтэний байр суурь илүү өндөрөөр үнэлэгдэнэ.  
C. Байгууллагад хувь хүмүүс материаллаг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх, чөлөөт цаг ихтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна.  
D. Их хэмжээний баялгийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүтэй хүндэтгэдэг.  
E. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

### II. СОЁЛ

10. Асуултын тэмдгийн оронд соёлыг бүрдүүлэгч үндсэн элементийг нөхнө үү. /1 оноо/



- A. Ухаан  
B. Мэдрэмж  
C. Мэдлэг  
D. Домог  
E. Шашин

11. Биелгээ нь Монголчуудын аж амьдралаас үүсчээ. Биелгээнд ихэвчлэн амьдрал дээр хийж гүйцэтгэдэг зан үйлүүдийг хийдэг. Жишээ нь: цайныхаа дээж, цацлыг уул усандаа өргөх, юм оёх, тариа тээрэмдэх буюу тариа татах, ноос савах, бөх барилдах, нум сум харвах, морины явдал зэргээр биелдэг. Биелгээний хөдөлгөөн, дохио зангаа нь мэдлэг, ..... юм. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. хэм хэмжээ    B. мэдрэмж    C. үнэлэмж    D. хэл    E. бэлгэдэл

12. “Суурь үнэлэмжүүд өөр өөр байж болно” гэсэн шалгуур үзүүлэлтээр соёлыг хэрхэн ангилан судалдаг вэ? /1 оноо/

- A. эртний, дундад, орчин үеийн  
 B. олон улсын, улс үндэстний  
 C. нэг хэв загварын, олон хэв загварын  
 D. ёс суртахууны, шашны  
 E. олонхийн, зонхилох, дэд соёл

13. Доорх соёлын хэв маягийг түүхэн дарааллаар нь байршуулна уу. /2 оноо/

1. Эртний  
 2. Хүй нэгдлийн  
 3. Дундад зууны  
 4. Сэргэн мандалтын  
 5. Шинэ үеийн  
 6. Орчин үеийн  
 A. 1, 3, 2, 4, 6, 5  
 B. 1, 3, 2, 4, 5, 6  
 C. 2, 1, 3, 4, 5, 6  
 D. 2, 1, 3, 4, 6, 5  
 E. 1, 3, 2, 5, 4, 6

14. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үл хамаарах салбарыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. дизайн, дүрслэх урлаг  
 B. мэдээллийн технологи  
 C. соёлын өв  
 D. тайзны уран бүтээл  
 E. кино урлаг

15. Зам харилцаа, эдийн засгийн харилцаа, мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг ..... гэнэ. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. соёлын аялал жуулчлал  
 B. соёлын эрх чөлөө  
 C. соёлын үйлдвэрлэл  
 D. соёлын даяаршил  
 E. соёлын орон зай

16. Соёлын даяаршил нь нийгэмд олон талын боломжийг олгодог. Өгүүлбэрийн эхлэлийг тохирох төгсгөлтэй нь харгалзуулна уу. /3 оноо/

a	Мэдээлэл, бараа бүтээгдэхүүн, хүн хүчээ ч дэлхий	1	зуурт авах, өгөх боломж
b	Ямар ч төрлийн мэдээллийг хоромхон	2	даяар солилцох, хамтран ажиллаж, хамтдаа хөгжих боломж
c	Чөлөөт худалдаа, олон улсын худалдаа, бизнесийн үйл ажиллагаа тэлэн	3	хөгжих, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд борлуулах боломж
d	Олон ургалч соёл дэлгэрч янз	4	бүрийн соёлыг мэдрэх боломж

- A. a2, b1, c3, d4  
 B. a2, b4, c1, d3  
 C. a3, b4, c1, d2  
 D. a4, b1, c2, d3  
 E. a3, b2, c4, d1

17. Эдгээрээс аль нь соёлын эрх чөлөөг илэрхийлэх асуудал вэ? /1 оноо/

- A. хэн нэгний эрх чөлөөнд халдах  
 B. эрхээ эдлэхгүй байх  
 C. амьдрах хэв маягийг тулгахгүй байх  
 D. өөр соёлын орчин тухайн хүний хүссэнээс огт өөр байх сөрөг мэдрэмж  
 E. бусдын санал бодлыг зөвшөөрөхгүй байх

18. Соёлын эрх чөлөө нь тухайн хүний харъяалж буй улсаас их шалтгаална. Манай улсын хувьд 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш нийгмийн оюун санааны амьдралд олон өөрчлөлт гарсан билээ. Тэрхүү өөрчлөлтүүдийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

1. үг хэлэх, чөлөөтэй ярих, бичих, хэвлэн нийтлэх эрх чөлөө  
 2. үндэсний чөлөөт хэвлэл бүрэлдэн бий болох эрх чөлөө  
 3. бусад соёлыг хуулбарлан шууд дууриах эрх чөлөө  
 4. авьяас билгээ дайчлах, бүтээн туурвих эрх чөлөө  
 5. үндэсний үзэл санаа, соёл, уламжлалаа сэргээн мандуулах эрх чөлөө  
 A. 2, 3, 4  
 B. 1, 2, 3, 4  
 C. 1, 2, 3, 5  
 D. 2, 3, 4, 5  
 E. 1, 2, 4, 5

### III. ЭДИЙН ЗАСАГ

19. Дотоодын нийт бүтээгдэхүүний зардлаар тооцох үзүүлэлтэд аль нь хамаарагдах вэ? /1 оноо/

- A. Түрээс  
 B. Зээлийн хүү  
 C. Ашиг  
 D. Цэвэр экспорт  
 E. Цалин

20. Орон нутагт улсын төсвөөс 150 км зам тавьж ашиглалтад оруулсан бол дотоодын нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн ямар зардлаар тооцох вэ? /1 оноо/

- A. Төрийн зардал  
 B. Аж ахуйн нэгжийн зардал  
 C. Өрх гэрийн зардал  
 D. Гадаадын хэрэглэгчийн зардал  
 E. Цэвэр экспорт

21. Хувьцаа гэж юу вэ? /1 оноо/

- A. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаас  
 B. Засгийн газраас худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан баримт бичиг  
 C. Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримт бичиг  
 D. Хуулийн дагуу тогтоосон хэмжээгээр хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж  
 E. Төрийн байгууллагын зүгээс үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хуулийн этгээдээс авч байгаа хураамж

22. Татварыг бүх нийтээр төлдөг байх, хүмүүсийн орлоготой шууд хамааралтай байх нь татвар хураалтын ямар зарчим бэ? /1 оноо/

- A. Заавал төлдөг байх  
 B. Ил тод байх  
 C. Тэгш байх  
 D. Шударга байх  
 E. Энгийн байх

23. Төсвийн дефицит үзэгдлийн илрэх шинжийг доорх өгөгдлөөс олно уу. /1 оноо/

- A. Төсвийн урсгал болон нийт зарлага багасаж шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ  
 B. Төсвийн зарлагаас орлого нь давж санхүүгийн харилцаанд хүндрэл учруулна  
 C. Төсвийн орлого зарлагын үзүүлэлтүүд тэнцвэржиж төрийн санхүү тогтворжино  
 D. Төсвийн санхүүжилт татварын орлогоос бус хураамжийн орлогоос хамаарна  
 E. Төсвийн орлогоос зарлага нь давж санхүүгийн харилцаанд хүндрэл учруулна

24. Эдийн засаг судлаач Ф. Хайекийн боловсруулсан үзэл санааг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байгаа  
 B. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй  
 C. Нийт эрэлтийг төрийн оролцоотойгоор нэмэгдүүлж болно  
 D. Нийт оролцоог төрийн оролцоотойгоор нэмэгдүүлж болохгүй  
 E. Төрийн зардлыг өөрчлөхгүйгээр зээлийн хүүг нэмэгдүүлэх боломжтой.

25. Зээлийн хүүг бууруулах нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ? /3 оноо/

- A. Банкны зээлийн хүү нэмэгдэхэд иргэд аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хэмжээ өсч, хүмүүс мөнгөтэй болсноор нийт эрэлт нэмэгдэнэ  
 B. Банкны зээлийн хүү буурахад иргэд аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хэмжээ буурч, хүмүүс мөнгөтэй болсноор нийт эрэлт нэмэгдэнэ  
 C. Банкны зээлийн хүү буурахад иргэд аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хэмжээ өсч, хүмүүс мөнгөтэй болсноор хэрэглээ нэмэгдэж, нийт эрэлт нэмэгдэнэ  
 D. Банкны зээлийн хүү нэмэгдэхэд иргэд аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хэмжээ өсч, хүмүүс мөнгөтэй болсноор нийт эрэлт буурна  
 E. Банкны зээлийн хүү буурахад иргэд аж ахуйн нэгжүүдийн авах зээлийн хэмжээ өсч, хүмүүс мөнгөтэй болсноор нийт эрэлт тогтворжино



26. Улс орнуудын хооронд бараа үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг ..... гэнэ. Цэгийн оронд тохирох өгөгдлийг нөхнө үү /1 оноо/

- A. Олон улсын худалдаа  
B. Гадаад худалдааны тэнцэл  
C. Барааны нийт эргэлт  
D. Гадаад худалдааны бодлого  
E. Олон улсын харилцаа

27. Тухайн улсын эдийн засгийн чадавхийг харуулдаг үндсэн үзүүлэлтийг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
B. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
C. Үндэсний цэвэр бүтээгдэхүүний хэмжээ  
D. Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
E. Эдийн засгийн бүсүүдийн орлогын хэмжээ

#### IV. УЛС ТӨР

28. Иргэдэд төрийн бүх үйл ажиллагаа ил тод байхыг илэрхийлдэг ардчиллын зарчим аль нь вэ? /1 оноо/

- A. Зөвшилцөлд хүрэх зарчим  
B. Шударга байх зарчим  
C. Хууль дээдлэх зарчим  
D. Цөөнхийг хүндэтгэх зарчим  
E. Нээлттэй байх зарчим

29. Монгол улсын ерөнхийлөгч чиг үүргийнхээ хүрээнд эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /1 оноо/

- A. Захирамж  
B. Тогтоол  
C. Зарлиг  
D. Хууль  
E. Тушаал

30. Иргэний нийгмийн түгээмэл шинжүүдэд үл хамаарах өгөгдөл аль нь вэ? /2 оноо/

- A. Хүний эрх, эрх чөлөөг эрх үүрэг, хариуцлагын зохист нэгдэлд нь хуулийн хүрээнд хүн бүхэнд адил тэгшээр эдлүүлдэг байх  
B. Үндэсний соёлыг чухалчлан үзэж бусад соёлоос суралцах үйл явцад төрийн зүгээс хатуу хяналт тавих  
C. Эрх мэдлийг зохистой хуваарилан тэнцвэржүүлж, нийгмийн харилцааг зохицуулах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх  
D. Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжин зах зээлийн эрүүл саруул тогтолцоог хөгжүүлэх  
E. Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэдийн оролцооны эрх эрх чөлөөг баталгаажуулсан орчин бүрдүүлэх

31. Иргэний нийгмийн төлөвшил улс төрийн хүрээнд ямар үйл ажиллагаагаар илрэн явагддаг вэ? /1 оноо/

- A. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг дэмжих  
B. Иргэд хувийн өмчтэй байж, өмчийн олон хэлбэрүүд эрх тэгш хөгжих  
C. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үүрэг хариуцлагыг адил тэгш эдлүүлэх  
D. Олон намын тогтолцоо бүхий ардчилсан сонгуулийн систем бүрэлдэх  
E. Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ шударгаар өрсөлдөх боломж бий болох

32. Бүх нийтээр оролцох сонгуулийн зарчмыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох  
B. Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх  
C. Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх  
D. Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх  
E. Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

33. Сонгогчдоос 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ? /1 оноо/

- A. Саналыг харгалзах  
B. Харьцангуй олонх  
C. Үнэмлэхүй олонх  
D. Хувь тэнцүүлэх  
E. Энгийн олонх

34. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэхдээ баримталдаг зарчмуудад хамаарахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Ард түмний эрх ашгийг илэрхийлсэн дуу хоолой байх  
B. Нэг хүний эрх ашгийн төлөө бус үнэн зөв мэдээлэл дамжуулах  
C. Бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах  
D. Эрх баригч намын байр суурийг бэхжүүлэх мэдээлэл дамжуулах  
E. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах

35. 2015 оны ардчилсан засаглал судалгааны дүнгээс: *Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь улс төрөөс хараат бус байдаг гэдэгтэй судалгаанд хамрагдсан иргэдийн 42,6 хувь нь санал нийлдээгүй, 23,0 хувь нь дунд зэрэг, 8,2 хувь нь санал нийлдэг* гэж үзжээ. Дээрх эх сурвалж ямар асуудлын тухай мэдээлэл вэ? /3 оноо/

- A. Мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх шашны судалгааны дүгнэлт  
B. Улс төрийн намуудын санхүүгээс хараат бус байдлын талаарх иргэдийн санал  
C. Мэдээллийн хэрэгслийн улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн төсөөлөл  
D. Сонирхлын бүлгүүд улс төрөөс хараат бус байдлын талаарх иргэдийн санал  
E. Иргэний нийгмийн зохион байгуулалтын үйл ажиллагааны шаардлага

36. Г. Алмондын судалснаар аномик шинжтэй бүлгийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын гол онцлог юу вэ? /1 оноо/

- A. Тодорхой зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлэг  
B. Тодорхой зохион байгуулалтгүй цугларалт, бослого, үймээн  
C. Гол төлөв яс үндэс, шашин шүтлэг, нас хүйсээрээ нэгддэг бүлэг  
D. Цэрэг арми, сүм хийдийн дор зохион байгуулагдан үүсдэг бүлэг  
E. Өөрсдийн эрх ашгийг илэрхийлсэн явцуу, хууль бус үүсдэг бүлэг

#### V. ЭРХ ЗҮЙ

37. Хүний эрхэм чанарын үндсэн шинжид аль нь хамаарах вэ? /1 оноо/

- A. Хүний эрхэм чанар тухайн хүнээс өөрөөс нь шалтгаална  
B. Хүний эрхэм чанар нь хүн бүрд харилцан адилгүй байна  
C. Хүний эрхэм чанар нь хэмжигдэх үнэт зүйл  
D. Хүний эрхэм чанарыг хүнээс салгаж үл болно  
E. Хүний эрхэм чанарт хэн нэгэн нөлөөлж чадна

38. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан тэгш байдлыг хангах зарчмыг илэрхийлсэн утгыг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг хүлээнэ.  
B. Арьс өнгө, хүйс, хэл яриа, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал зэргээс үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй  
C. Бүх хүн аливаа ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай байх  
D. Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл байна.  
E. Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг.

39. Иргэний эрх зүйн харилцаа нь хүний эрх, эрх чөлөөний үндэс болохын хувьд ямар зарчмаар баталгаажсан байдаг вэ? /1 оноо/

- A. чадвар, чадамжийн B. тэгш байдлын  
C. түгээмэл тунхаглалын D. эрх үүргийн E. хүний чөлөөт байдлын

40. Хөдөлмөрийн тухай хуулийн 40-р зүйлд зааснаар ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл аль нь вэ? /1 оноо/

- A. Өөрийн хүсэлтээр  
B. Насанд хүрээгүй  
C. Удирдах албан тушаалтантай зөрчилдсөн  
D. Ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл гаргасан нь тогтоогдсон  
E. Ар гэрт гэнэтийн ажил гарахад

41. Засаглалын эрх мэдлийг хуваарилах, хүний эрхийг баталгаажуулах, улс орны суурь гол харилцааг зохицуулах үүрэгтэй хамгийн дээд хүчин чадалтай засаг, төрийн гол хууль аль нь вэ? /1 оноо/

- A. Захиргааны хэргийн хууль B. Иргэний хууль C. Үндсэн хууль  
D. Хөдөлмөрийн тухай хууль E. Эрүүгийн хууль

42. Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн нийгэмд аюултай гэмт хэрэгт аль нь орох вэ? /2 оноо/

1. Алдаатай гүйлгээ, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших  
2. Эд хөрөнгийг хувьчлан авах  
3. Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах  
4. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх  
A. 1, 2, 3, 4 B. 1, 3, 4 C. 1, 2, 3 D. 2, 3, 4 E. 1, 2, 4

**Эхийг анхааралтай уншаад 43, 44-р асуултад хариулна уу.**

Иргэн Ж-г ажилдаа явсан хойгуур түүний байшингийн цонхоор Б орж эд зүйлийг нь хулгайлж авсан байна. Б-гийн үйлдлийг хамар хашааны иргэн О харсан боловч энэ талаар хэнд ч хэлээгүй.

43. О-гийн үйлдэл эрх зүйн зөрчлийн аль ангилалд орох вэ? /1 оноо/

- A. Хуулийн хүрээний B. Гэмт хэргийн бус C. Ёс зүйн  
D. Гэмт хэргийн E. Хуулийн бус хүрээний

44. Иргэн Б-гийн үйлдэл эрх зүйн зөрчлийн аль ангилалд орох вэ? Ямар хуулийн хүрээнд шийдэгдэх вэ? Доорх өгөгдлийг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /3 оноо/

Эрх зүйн зөрчлийн ангилал		Хууль	
a	Гэмт хэргийн	1	Эрүүгийн
b	Гэмт хэргийн бус	2	Иргэний
c	Ёс зүйн	3	Захиргааны хэргийн
d	Хуулийн	4	Хөдөлмөрийн

- A. a1 B. a2 C. b1 D. c4 E. d3

**Эхийг анхааралтай уншаад 45, 46-р асуултад хариулна уу.**

Иргэн Б 2018 онд газар авсан боловч газраа ашиглалгүй 1 жил болжээ. Жилийн дараа газраа эргэхээр очиход нь иргэн Г газар дээр нь хашаа байшин барьсан байв. Иргэн Г-д дүүргийн засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 274 дугаар захирамжаар газар олгосон баримт бичиг байв. Харин иргэн Б-д дүүргийн засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 109 дүгээр захирамж байв. Иргэн Б захиргааны хэргийн шүүхэд хандан гомдол гаргажээ.

*Энэ тохиолдолд Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 12-т “Монгол улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй” гэсэн заалтын дагуу Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх үйл ажиллагааг шүүх бус дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан явуулжээ.*

45. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч “бусад оролцогч” гэсэн субъектэд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Хэлмэрч, орчуулагч B. Өмгөөлөгч C. Гэрч  
D. Шинжээч E. Гомдол гаргагч иргэн

46. Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг иргэн Б эс зөвшөөрч захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргах болжээ. Иргэн Б нэхэмжлэлдээ юуг тусгах вэ? Зөвийг олно уу? /3 оноо/

1	Нэхэмжлэгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг
2	Нэхэмжлэлийн зорилго, ач холбогдол
3	Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл

- A. 1 B. 2, 3 C. 1, 2 D. 1, 3 E. 3

**VI. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА**

47. Де-факто гэдэг олон улсын хэллэг нь ямар утгыг илэрхийлдэг вэ? /1 оноо/

- A. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
B. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
C. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
D. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
E. Соёл урлагийн ойлголтоор тухайн улсыг хүлээн зөвшөөрсөн хэлбэр

48. Өөрийн орны болон бүс нутгийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш холбоотон улсууд, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг улсыг олон улсын харилцааны “улс” оролцогчийн аль ангилалд хамруулдаг вэ? /1 оноо/

- A. Бага улс B. Их гүрэн C. Дунд улс D. Хөрш орон E. Хаант улс

49. Монгол улсын гавьяат тамирчин М. Бундмаа Хонконгийн шигшээ багийн урилгаар жудо бөхийн дасгалжуулагчаар ажиллаж өндөр амжилт гаргажээ. Бундмаа гавьяат олон улсын харилцаанд хэрхэн оролцож байна вэ? /1 оноо/

- A. Урлагийн чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
B. Шашны чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
C. Төрийн бус байгууллагын чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
D. Спортын чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
E. Хувийн эрх ашгийн үүднээс эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.



50. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны олон тулгуурт бодлогын үндсэн илрэлийг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэх
- B. Олон оронтой, цөөн хэлбэрийн харилцаа явуулах
- C. Нөөц бололцоогоо бүрэн дайчлан зохион байгуулах
- D. Шат дарааллыг эрхэмлэн том орнуудын сонирхлыг тэнцвэржүүлэх
- E. Олон оронтой, олон хэлбэрийн харилцаа явуулах

51. НҮБ тэргүүтэй нийтлэг байгууллагууд нь олон улсын харилцааны улс бус оролцогчийн аль ангилалд хамаарах вэ? /1 оноо/

- A. Олон улсын байгууллага
- B. Олон улсын төрийн бус байгууллага
- C. Үндэстэн дамнасан корпорац
- D. Нөлөө бүхий хувь хүн
- E. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ

52. Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл болсон олон улсын харилцааны улс бус оролцогчийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Далай лам
- B. Тоёота корпораци
- C. НҮБ
- D. "Эмнэсти интернэйшнл"
- E. ЮНЕСКО

53. Зүүн хойд Азийн бүс нутагт байрлах улс орныг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Энэтхэг
- B. Вьетнам
- C. Монгол
- D. Казахстан
- E. Индонези

54. "АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх болно." гэж Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заажээ. Монгол улс яагаад "Гуравдагч хөрш"-ийн бодлогыг хэрэгжүүлэх болсон бэ? /3 оноо/

- A. Монгол улс зөвхөн БНХАУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- B. Монгол улс Азийн бүсийн хамааралд бус Америк, Европын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- C. Монгол улс зөвхөн ОХУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- D. Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- E. Монгол улс зөвхөн Буриад, Өвөр Монголын хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.

55. Ёс суртахууныг эрхэмлэн ямар ч үед, аль ч нөхцөлд эмзэг бүлгийн нийтлэг ашиг сонирхлыг хүндэтгэсэн үйл ажиллагаа явуулж байгаа зөөлөн хүчний бодлогын чиглэлийг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Улс төрийн дипломат ажиллагаа
- B. Эдийн засгийн дипломат ажиллагаа
- C. Соёлын дипломат ажиллагаа
- D. Цахим дипломат ажиллагаа
- E. Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа

56. Доорх ойлголтуудад үндэслэсэн зөв бодомжийг тэмдэглэнэ үү.

/3 оноо/

Зөөлөн хүч гэдэг нь бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар бусад нөлөөлөх чадвар, үйл ажиллагаа	Хатуу хүч гэдэг нь улс төр, эдийн засгийн чадавхдаа дулдуйдан хүчээр түрий барих бодлого	Ухаалаг хүч гэдэг нь өөрт байгаа бүх боломжоо тэнцвэртэй хэрэглэх чадвар, үйл ажиллагаа
--	--	---

- A. Зөөлөн хүчний бодлого бол хатуу ба ухаалаг хүчийг зөрчилдүүлэх зарчим, арга зүйд суурилна.
- B. Хатуу хүчний бодлого бол ухаалаг ба зөөлөн хүчийг хослуулах зарчим, арга зүйд суурилна.
- C. Ухаалаг хүчний бодлого бол зөөлөн хүчийг хатуу хүчний бодлогод захируулах зарчим, арга зүйд суурилна.
- D. Ухаалаг хүчний бодлого бол хатуу ба зөөлөн хүчийг хослуулах зарчим, арга зүйд суурилна.
- E. Зөөлөн хүчний бодлого бол ухаалаг хүчийг хатуу хүчний бодлогод захируулах зарчим, арга зүйд суурилна.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТОХИРУУЛАХ, ХАРГАЛЗУУЛАХ,  
ИЛҮҮЦИЙГ ОЛОХ ДААЛГАВАР**

Санамж:

1. Энэ хэсэг нь ойлголт, ухагдахууныг зөв тохируулах, харгалзуулах, илүүцийг олох даалгавар юм.
2. Зөв тохируулж, харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Дараах нийгмийн хэв маягуудыг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /5 оноо/

a	Ан агнуурын нийгэм	1	Анжис хэрэглэн тариа тарих ба худалдаа арилжаа үүссэн нийгэм
b	Цэцэрлэг аж ахуйн нийгэм	2	Чулуун сүх, жад, хутга зэрэг зэвсэг ашигладаг, овгийн байгуулалттай
c	Газар тариалангийн нийгэм	3	Даяаршил, мэдээлэл технологийн хурдац маш өндөр түвшинд явагдана.
d	Аж үйлдвэржсэн нийгэм	4	Нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, овог төрлийн харилцаатай
e	Аж үйлдвэржилтийн дараах нийгэм	5	Дулаан, цахилгаан, атомын эрчим хүчийг ашиглан аж ахуй эрхэлдэг

2.2. Соёлын үйлдвэрлэл ямар ач холбогдолтой вэ? Өгүүлбэрийн эхлэлийг тохирох төгсгөлтэй нь харгалзуулна уу. (2-р баганад хоёр илүү төгсгөл байгааг анхаараарай.) /5 оноо/

- |   |  |
|---|--|
| a. Ажлын  | 1. шинжийг нээн илрүүлдэг.                             |
| b. Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх  | 2. байр нэмэгдүүлдэг.                                  |
| c. Улс орнуудыг соёл, ёс  | 3. боломжийг бий болгоно.                              |
| d. Эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, харилцан хүндлэл, нийгмийн шударга ёсны зарчим, үнэ | 4. заншлаар нь ялган таниулах гол арга зам болдог.     |
| e. Соёлын үйлдвэрлэл дэх иргэдийн оролцоо нь нийгмийг   | 5. цэнийг дэлгэрүүлж, бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. |
|   | 6. нягтруулж, нийгмийн бүлгийг хүчирхэг болгодог.      |
|   | 7. амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг.                   |

2.3. Улс төрийн систем, түүний дэд систем, чиг үүргийг холбогдох утгатай нь зөв тохируулна уу. /5 оноо/

a	Улс төрийн систем	1	Нийгэмд засаглалыг зохион байгуулан нийгмийн баялгийг хуваарилан байршуулах, эрх зүйн хийгээд улс төрийн хэм хэмжээ дэг журмын цогц, төр улс иргэд нийгмийн байгууллагуудын нэгдэл
b	Тогтолцооны (институциональ) дэд систем	2	Шаардлага, дэмжлэг бүхий оролтыг хувирган шийдвэр үйлдэл бүхий гаралтыг бий болгон улмаар эргэх холбоонд хамрагдаж байдаг орчил хөдөлгөөний дэд систем
c	Мэдээлэл-харилцааны (коммуникаци) дэд систем	3	Улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох хэм хэмжээнээс бүрддэг дэд систем
d	Хэм хэмжээ-зохицуулалтын дэд систем	4	Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах үүрэг бүхий дэд систем
e	Улс төрийн системийн чиг үүрэг	5	Улс төрийн нийгэмшилтийг хангах, сонирхлыг илрүүлэх, нэгтгэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянах үйл явц, үйл ажиллагаа.

2.4. Иргэдийн ажилгүй болсон шалтгаан нөхцлийг ажилгүйдлийн хэлбэрээр бүлэглэн холбогдох жишээ баримттай нь зөв тохируулна уу. (Доорх ажилгүйдлийн хэлбэрүүдэд үл тохирох 1 илүү жишээ 2-р баганад байгааг анхаараарай.) /5 оноо/

Энэхүү үйлдлийг хийхдээ дараах ухагдахуунуудад үндэслээрэй. Үүнд:

- ✓ Эдийн засгийн хямралаас үүдэлтэй ажилгүйдэл (мөчлөгийн ажилгүйдэл)
- ✓ Шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй ажилгүйдэл (шилжилтийн ажилгүйдэл)
- ✓ Улирлын байдлаас үүдэлтэй ажилгүйдэл (улирлын ажилгүйдэл)
- ✓ Ажил мэргэжлийн эрэлтээс үүдэлтэй ажилгүйдэл (бүтцийн ажилгүйдэл)
- ✓ Хувь хүний хэрэгцээ сонирхлоос үүдэлтэй ажилгүйдэл (завсрын ажилгүйдэл)

- |                          |   |
|--------------------------|---|
| a. Мөчлөгийн ажилгүйдэл  | 1. Дорж барилга дээр ажилладаг ч өвлийн улирал эхэлсэн учир түр ажилгүй байгаа.             |
| в. Шилжилтийн ажилгүйдэл | 2. Чимгээгийн нөхөр нийслэлд ажиллахаар болсон тул Чимгээ хотод түр ажилгүй байгаа.         |
| с. Улирлын ажилгүйдэл    | 3. Иргэдийн амьжиргаа муудаж олон үйлдвэрийн газар хаагдаж Бат ажилгүй болсон               |
| d. Бүтцийн ажилгүйдэл    | 4. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт буурч олон уурхайчид ажилгүй болсон                 |
| e. Завсрын ажилгүйдэл    | 5. Улс төрийн нэг нам сонгуульд ялж нөгөө намын төрийн албан хаагчид ажилгүй болсон         |
|                          | 6. Анужин мэргэжлээ дээшлүүлэхийн тулд гадаад хэл сурахаар ажлаа түр орхиж, ажилгүй байгаа. |

# ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ-2026 БАГА СУНГАА СОРИЛ

## Хувилбар D

### I. НИЙГЭМ, НИЙГМИЙН ХАРИЛЦАА

1. Социологич В. Занден “Нийгмийн хэсэг, элементүүдийн хооронд бэхжсэн тогтвортой харилцаа холбоо бол ..... юм” гэжээ. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. Нийгмийн байр суурь    B. Нийгэм    C. Нийгмийн бүтэц  
D. Нийгмийн үүрэг    E. Нийгмийн институт

2. Хүүхдүүд хамтран тоглох явцдаа дүрмээ хэлэлцэн тогтож, зохион байгуулалтад орж, бие даасан шийдвэр гаргах, гэр бүлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоход суралцдаг. Энэ нь нийгэмшилтийн аль агентад хамаарах вэ? /1 оноо/

- A. Хэвлэл мэдээлэл    B. Сургууль    C. Гэр бүл  
D. Үе тэнгийнхэн    E. Ажлын байр

3. Доорх ойлголтуудыг тодорхойлолттой нь зөв харгалзуулна уу. /3 оноо/

a	Нийгмийн гажуудал (девиаци)	1	Нийгэм, нийгмийн бүлгийн олонх гишүүдийн хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, хүлээлттэй үл нийцэх төлөвийг хэлнэ.
b	Аялдах үйлдэл (конформист)	2	Нийгмийн хэм хэмжээ, хүлээлтэд нийцэх төлөвийг хэлнэ.
c	Нийгмийн хяналт	3	Гажуудлыг арилгах үүднээс нийгмийн гишүүдийн зүгээс гажуудагчийг шийтгэх, засан хүмүүжүүлэх зэрэг хэлбэрээр авч буй арга хэмжээнүүдийн цогц юм.

- A. a1, b2, c3    B. a1, b3, c2    C. a3, b2, c1  
D. a3, b1, c2    E. a2, b3, c1

4. Тоон судалгааны аргын онцлогийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Мэдээлэл нь ажиглагдсан зан үйл, үг яриа байна  
B. Математик статистикийн аргуудаар шинжилгээ хийнэ  
C. Мэдээллийн утгыг ойлгох, дүрслэн харуулахаар зорино  
D. Стандарчлагдсан загварын дагуу үр дүнг бичих албагүй  
E. Задгай мэдээллээс ерөнхий сэдэв, нотолгоо гаргахыг зорино

5. XX зуунд дэлхийн хүн ам 1.65 тэрбумаас 6 тэрбум болтлоо өссөн нь нийгмийн ямар үзэгдэлтэй холбоотой вэ? /1 оноо/

- A. Нийгмийн судалгаа    B. Нийгмийн давхраажилт  
C. Нийгмийн гажуудал    D. Нийгмийн өөрчлөлт    E. Нийгмийн бүтэц

6. Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ зааглагдан хуваагдах нь нийгмийн ямар үзэгдэл вэ? /1 оноо/

- A. Нийгмийн давхраа    B. Нийгмийн давхраажилт  
C. Нийгмийн нийтлэг    D. Тэгш бус байдал    E. Нийгмийн ялгарал

7. “Тун цөөн хувийг эзэлнэ. Нийгмийн байр суурь нь харьцангуй нээлттэй байдаг” энэ шинжүүд нийгмийн ямар ангид хамаарах вэ? /1 оноо/

- A. Дээдийн доод    B. Дээдийн дээд    C. Дундын дээд  
D. Дундын дунд    E. Ажилчин анги

8. Нийгмийн давхраажилтыг судлах зөрчилдөөний онолын гол хандлагыг тэмдэглэнэ үү. /1 оноо/


- A. Бүх нийгэмд байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал оршин байдаг.  
B. Нэр хүнд, ажил мэргэжлийн байр суурийн ялгарал бол нийгмийн давхраажилтын суурь шалтгаан мөн  
C. Эрх мэдэл бүхий хэсэг өөрийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх давуу нөхцөлд байх бол бусад нь тэрхүү ашиг сонирхлыг хэрэгжүүлэхээр нөхцөлд байна  
D. Хөдөлмөрийн хуваарь нийгмийн зохион байгуулалтын үндэс болохын зэрэгцээ тэгш бус байдалд хүрэх үндсэн шалтгаан мөн  
E. Нийгмийн давхраажилт бол уламжлал, тогтсон байдлаас шалтгаалан өөрөө жам ёсоор оршин тогтнодог үзэгдэл мөн

9. Бүтэц-чиг үүргийн онолын үүднээс нийгмийн давхраажилтыг судалсан судлаач Т. Парсонсын жишээ загвар аль нь вэ? /2 оноо/

- A. Дэлгүүрийн эзэн, эмчийг нэр хүндээр өөрөөсөө илүү гэж үзвэл түүнийг дэлгүүрийн эзэнээс дээд ангид оруулж судална.  
B. Байгууллагад хувь хүмүүс материаллаг урамшуулал авах, эрх чөлөөтэй байх, нэр хүндтэй байх зэрэг олон янзын ашиг сонирхолтой байна.  
C. Их хэмжээний баялгийг шинээр олж авсан баяныг бус, харин ядуурч хоосорсон язгууртныг хүмүүс илүүтэй хүндэтгэдэг.  
D. Ер бусын хүчинтэй харилцахыг онцгой чухал гэж үзэх нийгэмд шашны зүтгэлтэн, санваартан, бөө, шидтэний байр суурь илүү өндөрөөр үнэлэгдэнэ.  
E. Ажил мэргэжлийн нэр хүндийн зэрэглэлийг тухайн хүний боловсрол, орлогын хэмжээгээр тодорхойлдог.

### II. СОЁЛ

10. Асуултын тэмдгийн оронд соёлыг бүрдүүлэгч үндсэн элементийг нөхнө үү. /1 оноо/



- A. Шашин  
B. Мэдрэмж  
C. Ухаан  
D. Домог  
E. Мэдлэг

11. Миний дүү Бат аавын бүсээр шилбүүрдэн тоглож байгаад ээжид зэмлүүлэв. Үүнийг хараад, аав дүү, бид хоёрт бүсээ дээдлэхийн утга учрын талаар ярьж өглөө. “Монгол хүн бүсийг сүлд хиймөр гэж үздэг. Тиймээс бүсээ дутуу бүслэн алдруулан, чирч явахыг цээрлэдэг, бүсээ чанга бүслэхийг төв чангын ..... гэх ба бүсний үзүүрийг өмнө талдаа гарган ороож, нөгөө үзүүрийг мөн урдаа шингээж уяна. Бүсээ гутал өмдөн дээрээ тавих буюу бүсний дээгүүр алхах гишгэхийг цээрлэдэг. Бүс, малгайтай хүн бол хэн ч халдашгүй чөлөөт иргэн гэсэн утгыг илтгэдэг” хэмээн ярьсан юм. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. үнэлэмж    B. мэдлэг    C. хэм хэмжээ    D. бэлгэдэл    E. ёс заншил

12. “Суурь үнэлэмжүүд өөр өөр байж болно” гэсэн шалгуур үзүүлэлтээр соёлыг хэрхэн ангилан судалдаг вэ? /1 оноо/

- A. нэг хэв загварын, олон хэв загварын  
 C. ёс суртахууны, шашны  
 E. олонхийн, зонхилох, дэд соёл
- B. олон улсын, улс үндэстний  
 D. эртний, дундад, орчин үеийн

13. Доорх соёлын түүхэн хэв маягаас аж ахуй эрхлэлтийг шалгуур болгосон ангилалд багтах төлөөллийг олно уу. /2 оноо/

1. ан агнуур  
 4. газар тариаланчдын соёл  
 A. 1, 3, 4, 6  
 D. 1, 2, 3, 4
2. түүвэрлэгчдийн соёл  
 5. өрнийн  
 B. 1, 3, 4, 5  
 E. 1, 2, 3, 5
3. нүүдэлчдийн соёл  
 6. дорнын  
 C. 1, 2, 4, 6

14. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үл хамаарах салбарыг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. мэдээллийн технологи  
 C. соёлын өв
- B. дизайн, дүрслэх урлаг  
 D. тайзны уран бүтээл  
 E. кино урлаг

15. Соёлуудын нэгдэн нягтрах үзэгдлийг бүхэлд нь ..... гэсэн ойлголтоор илэрхийлдэг. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/

- A. соёлын аялал жуулчлал  
 C. соёлын үйлдвэрлэл
- B. соёлын эрх чөлөө  
 D. соёлын даяаршил  
 E. соёлын орон зай

16. Соёлын даяаршил нь нийгэмд олон талын боломжийг олгодог. Өгүүлбэрийн эхлэлийг тохирох төгсгөлтэй нь харгалзуулна уу. /3 оноо/

a	Мэдээлэл, бараа бүтээгдэхүүн, хүн хүчээ ч дэлхий	1	хөгжих, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд борлуулах боломж
b	Ямар ч төрлийн мэдээллийг хоромхон	2	даяар солилцох, хамтран ажиллаж, хамтдаа хөгжих боломж
c	Чөлөөт худалдаа, олон улсын худалдаа, бизнесийн үйл ажиллагаа тэлэн	3	бүрийн соёлыг мэдрэх боломж
d	Олон ургалч соёл дэлгэрч янз	4	зуурт авах, өгөх боломж

- A. a2, b1, c3, d4  
 D. a4, b1, c2, d3
- B. a2, b4, c1, d3  
 E. a2, b3, c4, d1
- C. a3, b4, c1, d2

17. Доорх өгөгдлүүдийн аль нь “соёлын эрх чөлөө” хэмээх ухагдахууныг илэрхийлж байна вэ? /1 оноо/

- A. өөр соёлын орчин тухайн хүний хүссэнээс огт өөр байх сөрөг мэдрэмж  
 B. эрхээ эдлэхгүй байх  
 C. хүн бүрт олгогдсон адил тэгш боломж  
 D. хэн нэгний эрх чөлөөнд халдах  
 E. бусдын санал бодлыг зөвшөөрөхгүй байх

18. Соёлын эрх чөлөө нь тухайн хүний харьяалж буй улсаас их шалтгаална. Манай улсын хувьд 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш нийгмийн оюун санааны амьдралд олон өөрчлөлт гарсан билээ. Тэрхүү өөрчлөлтүүдийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

1. үг хэлэх, чөлөөтэй ярих, бичих, хэвлэн нийтлэх эрх чөлөө  
 2. үндэсний чөлөөт хэвлэл бүрэлдэн бий болох эрх чөлөө  
 3. бусад соёлыг шууд хуулбарлан дууриах эрх чөлөө  
 4. авьяас билгээ дайчлах, бүтээн туурвих эрх чөлөө  
 5. үндэсний үзэл санаа, соёл, уламжлалаа сэргээн мандуулах эрх чөлөө
- A. 2, 3, 4, 5  
 D. 1, 2, 4, 5
- B. 1, 2, 3, 4  
 E. 2, 3, 4
- C. 1, 2, 3, 5

### III. ЭДИЙН ЗАСАГ

19. Дотоодын нийт бүтээгдэхүүний зардлаар тооцох үзүүлэлтэд аль нь хамаарагдах вэ? /1 оноо/

- A. Аж ахуйн нэгжийн зардал  
 D. Түрээс
- B. Зээлийн хүү  
 E. Ашиг
- C. Цалин

20. Орон нутагт улсын төсвөөс 150 км зам тавьж ашиглалтад оруулсан бол дотоодын нийт бүтээгдэхүүний хэрэглэгчийн ямар зардлаар тооцох вэ? /1 оноо/

- A. Аж ахуйн нэгжийн зардал  
 C. Өрх гэрийн зардал  
 E. Цэвэр экспорт
- B. Төрийн зардал  
 D. Гадаадын хэрэглэгчийн зардал

21. Бонд гэж юу вэ? /1 оноо/

- A. Ямар нэг компанийн өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж буйг гэрчилсэн баримт бичиг  
 B. Засгийн газраас худалдах, худалдан авах эрхийг баталгаажуулсан баримт бичиг бүрдүүлэх үйл ажиллагаа  
 C. Тодорхой хэмжээний мөнгийг тогтоосон хугацааны дараа, зохих хүүтэйгээр эргүүлэн төлөхөө амлаж байгааг баталсан үнэт цаас  
 D. Хуулийн дагуу тогтоосон хэмжээгээр хуулийн этгээдээс төрд заавал төлөх, буцалтгүй шинжтэй хураамж  
 E. Төрийн байгууллагын зүгээс үйлчилгээ үзүүлснийхээ төлөө хуулийн этгээдээс авч байгаа хураамж

22. Татварыг бүх нийтээр төлдөг байх, хүмүүсийн орлоготой шууд хамааралтай байх нь татвар хураалтын ямар зарчим бэ? /1 оноо/

- A. Заавал төлдөг байх  
 D. Шударга байх
- B. Ил тод байх  
 E. Энгийн байх
- C. Тэгш байх

23. Төсвийн профицит үзэгдлийн илрэх шинжийг доорх өгөгдлөөс олно уу. /1 оноо/

- A. Төсвийн зарлагаас орлого нь давж санхүүгийн харилцаа эрчимжинэ  
 B. Төсвийн орлогоос зарлага нь давж санхүүгийн харилцаа эрчимжинэ  
 C. Төсвийн орлого зарлагын үзүүлэлтүүд тэнцвэржиж төрийн санхүү тогтворжино  
 D. Төсвийн санхүүжилт татварын орлогоос бус хураамжийн орлогоос хамаарна  
 E. Төсвийн урсгал болон нийт зарлага багасаж шууд хөрөнгө оруулалт нэмэгдэнэ

24. Эдийн засаг судлаач Ф. Хайекийн боловсруулсан үзэл санааг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байгаа  
 B. Гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ болон үнийн түвшний хооронд шууд холбоо байхгүй  
 C. Нийт эрэлтийг төрийн оролцоотойгоор нэмэгдүүлж болно  
 D. Нийт оролцоог төрийн оролцоотойгоор нэмэгдүүлж болохгүй  
 E. Төрийн зардлыг өөрчлөхгүйгээр зээлийн хүүг нэмэгдүүлэх боломжтой.

25. Гүйлгээнд байх мөнгөний хэмжээг өсгөх нь яагаад нийт эрэлтийг нэмэгдүүлдэг вэ? /3 оноо/

- A. Мөнгөний хумих бодлогыг явуулснаар нийт эрэлтийг нэмэгдүүлэх чухал нөхцөл бүрдэнэ  
 B. Мөнгөний хатуу бодлогыг явуулснаар нийт эрэлтийг нэмэгдүүлэх чухал нөхцөл бүрдэнэ  
 C. Мөнгөний тэлэх бодлогыг явуулснаар нийт эрэлтийг бууруулах чухал нөхцөл бүрдэнэ  
 D. Мөнгөний тэлэх бодлогыг явуулснаар нийт эрэлтийг тогтворжуулах чухал нөхцөл бүрдэнэ  
 E. Мөнгөний тэлэх бодлогыг явуулснаар нийт эрэлтийг нэмэгдүүлэх чухал нөхцөл бүрдэнэ



26. Улс орнуудын хооронд бараа үйлчилгээ шилжих хөдөлгөөнийг ..... гэнэ. Цэгийн оронд тохирох өгөгдлийг нөхнө үү /1 оноо/
- A. Гадаад худалдааны бодлого B. Гадаад худалдааны тэнцэл  
C. Барааны нийт эргэлт D. Олон улсын худалдаа  
E. Олон улсын харилцаа

27. Тухайн улсын иргэдийн амьжиргааны түвшинг илэрхийлдэг үзүүлэлтийг тэмдэглэнэ үү. /2 оноо/
- A. Нэг хүнд оногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
B. Бодит дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
C. Нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ  
D. Үндэсний цэвэр бүтээгдэхүүний хэмжээ  
E. Эдийн засгийн бүсүүдийн орлогын хэмжээ

#### IV. УЛС ТӨР

28. Иргэдэд төрийн бүх үйл ажиллагаа ил тод байхыг илэрхийлдэг ардчиллын зарчим аль нь вэ? /1 оноо/
- A. Шударга байх зарчим B. Нээлттэй байх зарчим  
C. Хууль дээдлэх зарчим D. Цөөнхийг хүндэтгэх зарчим  
E. Зөвшилцөлд хүрэх зарчим

29. Монгол улсын засгийн газар чиг үүргийнхээ хүрээнд эрх зүйн ямар акт гаргадаг вэ? /1 оноо/
- A. Хууль B. Захирамж C. Тогтоол D. Зарлиг E. Тушаал

30. Иргэний нийгмийн түгээмэл шинжүүдэд үл хамаарах өгөгдөл аль нь вэ? /2 оноо/
- A. Хүний эрх, эрх чөлөөг эрх үүрэг, хариуцлагын зохист нэгдэлд нь хуулийн хүрээнд хүн бүхэнд адил тэгшээр эдлүүлдэг байх  
B. Үндэсний соёлыг чухалчлан үзэж бусад соёлоос суралцах үйл явцад төрийн зүгээс хатуу хяналт тавих  
C. Эрх мэдлийг зохистой хуваарилан тэнцвэржүүлж, нийгмийн харилцааг зохицуулах, эрх зүйт төрийг төлөвшүүлэх  
D. Эдийн засгийн чөлөөт өрсөлдөөнийг дэмжин зах зээлийн эрүүл саруул тогтолцоог хөгжүүлэх  
E. Иргэдийн эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх, иргэдийн оролцооны эрх эрх чөлөөг баталгаажуулсан орчин бүрдүүлэх

31. Иргэний нийгмийн төлөвшил эдийн засгийн хүрээнд ямар үйл ажиллагаагаар илрэн явагддаг вэ? /1 оноо/
- A. Иргэд хувийн өмчтэй байж, өмчийн олон хэлбэрүүд эрх тэгш хөгжих  
B. Олон намын тогтолцоо бүхий ардчилсан сонгуулийн систем бүрэлдэх  
C. Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, үүрэг хариуцлагыг адил тэгш эдлүүлэх  
D. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бие даасан байдлыг дэмжих  
E. Эрх мэдлийг зохистой тэнцвэржүүлэн хуваарилж хуулиар баталгаажуулах

32. Бүх нийтээр оролцох сонгуулийн зарчмыг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- A. Чөлөөтэй сонголт хийн саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжтой байх  
B. Сонгогч бүр ижил тооны санал гаргах, санал бүр адил жинтэй байх  
C. Сонгуулийн эцсийн үр дүн нь иргэдийн санал хураалтаар шийдэгдэх  
D. Нас хүйс, яс үндэс, мэргэжил, үзэл бодлоос үл шалтгаалан оролцох  
E. Сонгогч зөвхөн өөрийн сонголтоор саналаа өгөх боломжтой байх

33. Сонгогчдоос хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцдог сонгуулийн тогтолцоо аль нь вэ? /1 оноо/
- A. Саналыг харгалзах B. Хувь тэнцүүлэх C. Үнэмлэхүй олонх  
D. Энгийн олонх E. Харьцангуй олонх

34. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэхдээ баримталдаг зарчмуудад хамаарахгүй өгөгдлийг тэмдэглэнэ үү. /1 оноо/
- A. Ард түмний эрх ашгийг илэрхийлсэн дуу хоолой байх  
B. Нэг хүний эрх ашгийн төлөө бус үнэн зөв мэдээлэл дамжуулах  
C. Бүх нийтэд тэгш хүргэх боломжийг нь хуулиар хангах  
D. Эрх баригч намын байр суурийг бэхжүүлэх мэдээлэл дамжуулах  
E. Хэвлэл мэдээллийн ажилтнуудын эрх ашгийг хамгаалах

35. 2016 оны судалгаагаар иргэдийн хэвлэл мэдээллийн байгууллагад итгэх итгэл Монголын үндэсний телевизэд 90 хувь, хувийн телевизэд 78 хувь, FM-радиоод 60 хувь гэсэн үнэлгээ өгчээ. Дээрх эх сурвалж ямар асуудлын тухай мэдээлэл вэ? /3 оноо/

- A. Хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд иргэдийн өгсөн төсөөлөл  
B. Хэвлэл мэдээллийн байгууллагад иргэдээс өгсөн итгэх итгэлийн судалгаа  
C. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн бус байгууллагуудын хандах байдал  
D. Хэвлэл мэдээллийн байгууллагад төрийн байгууллагуудын хандах байдал  
E. Хэвлэл мэдээллийн байгууллагад шашны судалгаа хийсэн дүгнэлт

36. Г. Алмондын судалснаар аноним шинжтэй бүлгийн үйл ажиллагаа, зохион байгуулалтын гол онцлог юу вэ? /1 оноо/
- A. Гол төлөв яс үндэс, шашин шүтлэг, нас хүйсээрээ нэгддэг бүлэг  
B. Тодорхой зорилго чиглэлтэй зохион байгуулалттай бүлэг  
C. Тодорхой зохион байгуулалтгүй цугларалт, бослого, үймээн  
D. Цэрэг арми, сүм хийдийн дор зохион байгуулагдан үүсдэг бүлэг  
E. Өөрсдийн эрх ашгийг илэрхийлсэн явцуу, хууль бус үүсдэг бүлэг

#### V. ЭРХ ЗҮЙ

37. Хүний эрхэм чанар нь ..... шууд холбоотой байдаг. Цэгийн оронд тохирох утгыг нөхнө үү. /1 оноо/
- A. хүний эрхтэй B. эрх ашигтай C. зохион байгуулалттай  
D. итгэх итгэлтэй E. хандах байдалтай

38. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан тэгш байдлыг хангах зарчмыг илэрхийлсэн утгыг тэмдэглэнэ үү. /2 оноо/
- A. Арьс өнгө, хүйс, хэл яриа, шашин шүтлэг, үзэл бодол, нийгмийн гарал, өмч хөрөнгө, төрсөн байдал зэргээс үл хамааран хэнийг ч ялгаварлан гадуурхаж болохгүй  
B. Бүх хүн аливаа ялгаваргүйгээр тэгш хүртэх түгээмэл шинж чанартай байх  
C. Хүн болж төрснийхөө хувьд хүн бүр ижил үнэ цэнтэй байж, адил хүндэтгэлийг хүлээнэ.  
D. Иргэний, улс төрийн, нийгэм эдийн засаг, соёлын болон хамтын эрх зэрэг хүний бүх эрхүүд нэгдмэл байна.  
E. Хүний эрх нь орон гэр, сургууль, ажлын байр, зах зэрэг газар бүрт, амьдралын бүхий л хүрээг хамардаг.

39. Иргэний эрх зүйн харилцаа нь ямар бүрдэл хэсгүүдтэй вэ? /1 оноо/

- A. үйлчилгээ, үйл ажиллагаа      B. агуулга, хэлбэр  
C. хууль, дүрэм, журам            D. хувь хүн, төр, байгууллага  
E. субъект, объект, агуулга

40. Хөдөлмөрийн тухай хуулийн 40-р зүйлд зааснаар ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл аль нь вэ? /1 оноо/

- A. Ажил олгогчийн итгэлийг алдсан буруутай үйлдэл гаргасан нь тогтоогдсон  
B. Насанд хүрээгүй  
C. Удирдах албан тушаалтантай зөрчилдсөн  
D. Өөрийн хүсэлтээр  
E. Ар гэрт гэнэтийн ажил гарахад

41. Ямар байгууллага Үндсэн хууль зөрчсөн талаар маргааныг шийдвэрлэж, хуульд заасан тодорхой байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд хяналт тавьдаг вэ? /1 оноо/

- A. Улсын дээд шүүх                      B. Харьяалах байнгын хороо  
C. Захиргааны шүүх                      D. Харьяа яам, тамгын газар  
E. Үндсэн хуулийн цэц

42. Өмчлөх эрхийн эсрэг чиглэсэн нийгэмд аюултай гэмт хэрэгт аль нь орох вэ? /2 оноо/

1. Алдаатай гүйлгээ, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших  
2. Эд хөрөнгийг хувьчлан авах  
3. Бусдын эд хөрөнгийг хамгаалахад хайнга хандах  
4. Болгоомжгүйгээр эд хөрөнгө устгах, гэмтээх, үрэгдүүлэх  
A. 2, 3, 4      B. 1, 2, 3, 4      C. 1, 2, 3      D. 1, 3, 4      E. 1, 2, 4

**Эхийг анхааралтай уншаад 43, 44-р асуултад хариулна уу.**

Иргэн С-г ажилдаа явсан хойгуур түүний байшингийн цонхоор Г орж эд зүйлийг нь хулгайлж авсан байна. Г-гийн үйлдлийг хамар хашааны иргэн Ц харсан боловч энэ талаар хэнд ч хэлээгүй.

43. Ц-гийн үйлдэл эрх зүйн зөрчлийн аль ангилалд орох вэ? /1оноо/

- A. Ёс зүйн                                      B. Гэмт хэргийн бус                                      C. Гэмт хэргийн  
D. Хуулийн хүрээний                      E. Хуулийн бус хүрээний

44. Иргэн Г-гийн үйлдэл эрх зүйн зөрчлийн аль ангилалд орох вэ? Ямар хуулийн хүрээнд шийдэгдэх вэ? Доорх өгөгдлийг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /3 оноо/

Эрх зүйн зөрчлийн ангилал		Хууль	
a	Гэмт хэргийн	1	Эрүүгийн
b	Гэмт хэргийн бус	2	Иргэний
c	Ёс зүйн	3	Захиргааны хэргийн
d	Хуулийн	4	Хөдөлмөрийн

- A. a1      B. a2      C. b1      D. c4      E. d3

**Эхийг анхааралтай уншаад 45, 46-р асуултад хариулна уу.**

Иргэн Б 2018 онд газар авсан боловч газраа ашиглалгүй 1 жил болжээ. Жилийн дараа газраа эргэхээр очиход нь иргэн Г газар дээр нь хашаа байшин барьсан байв. Иргэн Г-д дүүргийн засаг даргын 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 274 дугаар захирамжаар газар олгосон баримт бичиг байв. Харин иргэн Б-д дүүргийн засаг даргын 2018 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 109 дүгээр захирамж байв. Иргэн Б захиргааны хэргийн шүүхэд хандан гомдол гаргажээ.

*Энэ тохиолдолд Монгол улсын Үндсэн хуулийн 16-р зүйлийн 12-т "Монгол улсын иргэн төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалтын дагуу Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх үйл ажиллагааг шүүх бус дээд шатны захиргааны байгууллага, албан тушаалтан явуулжээ.*

45. Захиргааны хэргийг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч "бусад оролцогч" гэсэн субъектэд аль нь хамаарахгүй вэ? /1 оноо/

- A. Хэлмэрч, орчуулагч      B. Өмгөөлөгч                      C. Гэрч  
D. Шинжээч                      E. Гомдол гаргагч иргэн

46. Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг иргэн Б эс зөвшөөрч захиргааны хэргийн шүүхэд 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргах болжээ. Иргэн Б нэхэмжлэлдээ юуг тусгах вэ? Зөвийг олно уу? /3 оноо/

1	Нэхэмжлэгчийн ургийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг
2	Нэхэмжлэлийн зорилго, ач холбогдол
3	Нэхэмжлэлийн шаардлага, түүний үндэслэл

- A. 1      B. 2, 3      C. 1, 2      D. 1, 3      E. 3

**VI. ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА**

47. Де-юре гэдэг олон улсын хэллэг нь ямар утгыг илэрхийлдэг вэ? /1 оноо/

- A. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
B. Эрх зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн бус хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
C. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
D. Ёс зүйн ойлголтоор тухайн улсыг бүрэн хүлээн зөвшөөрсөн хэлбэр  
E. Соёл урлагийн ойлголтоор тухайн улсыг хүлээн зөвшөөрсөн хэлбэр

48. Өөрийн орны болон бус нутгийн аюулгүй байдлыг төдийгүй хөрш холбоотон улсууд, бус нутгийн аюулгүй байдлыг хангах хүчин чадалтай байдаг улсыг олон улсын харилцааны "улс" оролцогчийн аль ангилалд хамруулдаг вэ? /1оноо/

- A. Бага улс      B. Дунд улс      C. Их гүрэн      D. Хөрш орон      E. Хаант улс

49. НҮБ-ын энх тайвны элч, охидын боловсролын төлөө тэмцэгч Малала Юсуфзай интернетэд блог хөтөлж үе тэнгийнхэндээ төдийгүй дэлхий нийтэд мэдээлэл түгээжээ. Малала охин олон улсын харилцаанд хэрхэн оролцож байна вэ? /1 оноо/

- A. Урлагийн чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
B. Боловсрол, хүмүүнлэгийн чиглэлээр үнэн зөв мэдээлэл дамжуулж шударга бус үйл ажиллагааг илчилсэн  
C. Шашны чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
D. Төрийн бус байгууллагын чиглэлээр эзэмшсэн мэргэжил, туршлагаасаа хуваалцан хамтран ажиллаж үр дүнд хүрсэн.  
E. Хувийн эрх ашгийн үүднээс үнэн зөв мэдээлэл дамжуулж шударга бус үйл ажиллагааг илчилсэн



50. Монгол улсын олон улсын хамтын нийгэмлэг дэх оролцооны олон тулгуурт бодлогын үндсэн илрэлийг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Олон оронтой, олон хэлбэрийн харилцаа явуулах
- B. Олон оронтой, цөөн хэлбэрийн харилцаа явуулах
- C. Нөөц бололцоогоо бүрэн дайчлан зохион байгуулах
- D. Шат дарааллыг эрхэмлэн том орнуудын сонирхлыг тэнцвэржүүлэх
- E. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах зорилтуудыг хэрэгжүүлэх

51. "Хил хязгааргүй эмч нар" зэрэг байгууллагууд нь олон улсын харилцааны улс бус оролцогчийн аль ангилалд хамаарах вэ? /1 оноо/

- A. Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ
- B. Олон улсын байгууллага
- C. Үндэстэн дамнасан корпорац
- D. Нөлөө бүхий хувь хүн
- E. Олон улсын төрийн бус байгууллага

52. Олон улсын төрийн бус байгууллагын төлөөлөл болсон олон улсын харилцааны улс бус оролцогчийг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Далай лам
- B. Тоёота корпораци
- C. НҮБ
- D. "Эмнэсти интернэйшнл"
- E. ЮНЕСКО

53. АСЕАН-ны Бүсийн чуулгын (АРФ) гишүүн орныг тэмдэглэнэ үү. /1 оноо/

- A. Турк
- B. ОХУ
- C. Монгол
- D. Казахстан
- E. Иран

54. "АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой гуравдагч хөршийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх болно." гэж Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заажээ. Монгол улс яагаад "Гуравдагч хөрш"-ийн бодлогыг хэрэгжүүлэх болсон бэ? /3 оноо/

- A. Монгол улс зөвхөн БНХАУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- B. Монгол улс зөвхөн хоёр хөршийн хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- C. Монгол улс Азийн бүсийн хамааралд бус Америк, Европын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- D. Монгол улс зөвхөн ОХУ-ын хамааралд бус дээрх улсуудын нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.
- E. Монгол улс зөвхөн Буриад, Өвөр Монголын хамааралд бус тэдний нөлөөллийн тэнцвэрийг хадгалах зорилгоор энэхүү бодлогыг хэрэгжүүлж байна.

55. Үзэл санаа, үнэт зүйл, уламжлал, зан заншилд суурилан явуулж байгаа зөөлөн хүчний бодлогын чиглэлийг тэмдэглэнэ үү. /2 оноо/

- A. Соёлын дипломат ажиллагаа
- B. Эдийн засгийн дипломат ажиллагаа
- C. Хүмүүнлэгийн дипломат ажиллагаа
- D. Цахим дипломат ажиллагаа
- E. Улс төрийн дипломат ажиллагаа

56. Доорх ойлголтуудад үндэслэсэн зөв бодомжийг тэмдэглэнэ үү. /3 оноо/

Зөөлөн хүч гэдэг нь бусад улсын сэтгэлийг өөртөө татах замаар бусдад нөлөөлөх чадвар, үйл ажиллагаа	Хатуу хүч гэдэг нь улс төр, эдийн засгийн чадавхдаа дулдуйдан хүчээр түрий барих бодлого	Ухаалаг хүч гэдэг нь өөрт байгаа бүх боломжоо тэнцвэртэй хэрэглэх чадвар, үйл ажиллагаа
---	--	---

- A. Зөөлөн хүчний бодлого бол хатуу ба ухаалаг хүчийг зөрчилдүүлэх зарчим, арга зүйд суурилна.
- B. Хатуу хүчний бодлого бол ухаалаг ба зөөлөн хүчийг хослуулах зарчим, арга зүйд суурилна.
- C. Ухаалаг хүчний бодлого бол зөөлөн хүчийг хатуу хүчний бодлогод захируулах зарчим, арга зүйд суурилна.
- D. Зөөлөн хүчний бодлого бол ухаалаг хүчийг хатуу хүчний бодлогод захируулах зарчим, арга зүйд суурилна.
- E. Ухаалаг хүчний бодлого бол хатуу ба зөөлөн хүчийг хослуулах зарчим, арга зүйд суурилна.

**ХОЁРДУГААР ХЭСЭГ. ТОХИРУУЛАХ, ХАРГАЛЗУУЛАХ,  
ИЛҮҮЦИЙГ ОЛОХ ДААЛГАВАР**

**Санамж:**

1. Энэ хэсэг нь ойлголт, ухагдахууныг зөв тохируулах, харгалзуулах, илүүцийг олох даалгавар юм.
2. Зөв тохируулж, харгалзуулсан хариулт бүр 1 оноотой.

2.1. Дараах нийгмийн онцлогуудыг харгалзах утгатай нь зөв тохируулна уу. /5 оноо/

a	Ан агнуурын нийгэм	1	Дулаан, цахилгаан, атомын эрчим хүчийг ашиглан аж ахуй эрхэлдэг
b	Цэцэрлэг аж ахуйн нийгэм	2	Нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй, овог төрлийн харилцаатай
c	Газар тариалангийн нийгэм	3	Даяаршил, мэдээлэл технологийн хурдац маш өндөр түвшинд явагдана.
d	Аж үйлдвэржсэн нийгэм	4	Анжис хэрэглэн тариа тарих ба худалдаа арилжаа үүссэн нийгэм
e	Аж үйлдвэржилтийн дараах нийгэм	5	Чулуун сүх, жад, хутга зэрэг зэвсэг ашигладаг, овгийн байгуулалттай

2.2. Соёлын үйлдвэрлэл ямар ач холбогдолтой вэ? Өгүүлбэрийн эхлэлийг тохирох төгсгөлтэй нь харгалзуулна уу. (2-р баганад хоёр илүү төгсгөл байгааг анхаараарай.) /5 оноо/

- |   |  |
|---|--|
| a. Ажлын  | 1. цэнийг дэлгэрүүлж, бэхжүүлэх боломжийг нэмэгдүүлнэ. |
| b. Иргэдийн авьяасыг нээх, хөгжүүлэх  | 2. нягтруулж, нийгмийн бүлгийг хүчирхэг болгодог.      |
| c. Улс орнуудыг соёл, ёс  | 3. амьжиргааны түвшнийг дээшлүүлдэг.                   |
| d. Эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, харилцан хүндлэл, нийгмийн шударга ёсны зарчим, үнэ | 4. шинжийг нээн илрүүлдэг.                             |
| e. Соёлын үйлдвэрлэл дэх иргэдийн оролцоо нь нийгмийг   | 5. байр нэмэгдүүлдэг.                                  |
|   | 6. боломжийг бий болгоно.                              |
|   | 7. заншлаар нь ялган таниулах гол арга зам болдог.     |

2.3. Улс төрийн систем, түүний дэд систем, чиг үүргийг холбогдох утгатай нь зөв тохируулна уу. /5 оноо/

a	Улс төрийн систем	1	Нийгэмд засаглалыг зохион байгуулан нийгмийн баялгийг хуваарилан байршуулах, эрх зүйн хийгээд улс төрийн хэм хэмжээ дэг журмын цогц, төр улс иргэд нийгмийн байгууллагуудын нэгдэл
b	Тогтолцооны (институциональ) дэд систем	2	Улс төрийн системийн бүрдэл хооронд холбоо тогтоох, төр болон улс төрийн институтэд мэдээлэл дамжуулах үүрэг бүхий дэд систем
c	Мэдээлэл-харилцааны (коммуникаци) дэд систем	3	Шаардлага, дэмжлэг бүхий оролтыг хувирган шийдвэр үйлдэл бүхий гаралтыг бий болгон улмаар эргэх холбоонд хамрагдаж байдаг орчил хөдөлгөөний дэд систем
d	Хэм хэмжээ-зохицуулалтын дэд систем	4	Улс төрийн амьдрал дахь хүмүүсийн үйл байдал болон бусад объектын чиг үүргийг тодорхойлох хэм хэмжээнээс бүрддэг дэд систем
e	Улс төрийн системийн чиг үүрэг	5	Улс төрийн нийгэмшилтийг хангах, сонирхлыг илрүүлэх, нэгтгэх, шийдвэр гаргах, хэрэгжүүлэх, хянах үйл явц, үйл ажиллагаа.

2.4. Иргэдийн ажилгүй болсон шалтгаан нөхцлийг ажилгүйдлийн хэлбэрээр бүлэглэн холбогдох жишээ баримттай нь зөв тохируулна уу. (Доорх ажилгүйдлийн хэлбэрүүдэд үл тохирох 1 илүү жишээ 2-р баганад байгааг анхаараарай.) /5 оноо/

Энэхүү үйлдлийг хийхдээ дараах ухагдахуунуудад үндэслээрэй. Үүнд:

- ✓ Эдийн засгийн хямралаас үүдэлтэй ажилгүйдэл (мөчлөгийн ажилгүйдэл)
- ✓ Шилжилт хөдөлгөөнөөс үүдэлтэй ажилгүйдэл (шилжилтийн ажилгүйдэл)
- ✓ Улирлын байдлаас үүдэлтэй ажилгүйдэл (улирлын ажилгүйдэл)
- ✓ Ажил мэргэжлийн эрэлтээс үүдэлтэй ажилгүйдэл (бүтцийн ажилгүйдэл)
- ✓ Хувь хүний хэрэгцээ сонирхлоос үүдэлтэй ажилгүйдэл (завсрын ажилгүйдэл)

- |                          |   |
|--------------------------|---|
| a. Мөчлөгийн ажилгүйдэл  | 1. Дорж барилга дээр ажилладаг ч өвлийн улирал эхэлсэн учир түр ажилгүй байгаа.             |
| b. Шилжилтийн ажилгүйдэл | 2. Чимгээгийн нөхөр нийслэлд ажиллахаар болсон тул Чимгээ хотод түр ажилгүй байгаа.         |
| c. Улирлын ажилгүйдэл    | 3. Иргэдийн амьжиргаа муудаж олон үйлдвэрийн газар хаагдаж Бат ажилгүй болсон               |
| d. Бүтцийн ажилгүйдэл    | 4. Уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт буурч олон уурхайчид ажилгүй болсон                 |
| e. Завсрын ажилгүйдэл    | 5. Улс төрийн нэг нам сонгуульд ялж нөгөө намын төрийн албан хаагчид ажилгүй болсон         |
|                          | 6. Анужин мэргэжлээ дээшлүүлэхийн тулд гадаад хэл сурахаар ажлаа түр орхиж, ажилгүй байгаа. |

№	A	D	Овоо
1	C	C	1
2	B	D	1
3	D	A	3
4	E	B	1
5	A	D	1
6	C	E	1
7	B	A	1
8	D	C	1
9	A	D	2
10	C	E	1
11	E	D	1
12	D	C	1
13	C	D	2
14	B	A	1
15	D	D	1
16	A	B	3
17	C	C	1
18	E	D	1
19	D	A	1
20	A	B	1
21	C	C	1
22	D	D	1
23	E	A	1
24	B	B	1
25	C	E	3
26	A	D	1
27	D	A	2
28	E	B	1
29	C	C	1
30	B	B	2
31	D	A	1
32	A	D	1
33	E	E	1
34	D	D	1
35	C	B	3
36	B	C	1

37	D	A	1
38	A	C	2
39	E	E	1
40	D	A	1
41	C	E	1
42	B	D	2
43	D	C	1
44	A	A	3
45	E	E	1
46	D	D	3
47	C	A	1
48	B	C	1
49	D	B	1
50	E	A	2
51	A	E	1
52	D	D	1
53	C	C	1
54	D	B	3
55	E	A	2
56	D	E	3
2.1	a2	a5	1
	b4	b2	1
	c1	c4	1
	d5	d1	1
	e3	e3	1
2.2	a2	a5	1
	b3	b6	1
	c4	c7	1
	d5	d1	1
	e6	e2	1
2.3	a1	a1	1
	b2	b3	1
	c4	c2	1
	d3	d4	1
	e5	e5	1
2.4	a3	a3	1
	b2	b2	1
	c1	c1	1
	d4	d4	1
	e6	e6	1